

“МИНИЙ НУТАГ” СИСТЕМ

малчид, уул уурхайн компани хоёрыг “эвлэрүүлнэ”

Ж.ТЭПШЖАРГАЛ

Байгаль орчинд хохирол багатай, нутгийн иргэдэд хаялгатай, эдийн засгийн хувьд ашигтайгаар уул уурхайн олборлолт эрхлэхэд “Миний нутаг” мэдээллийн системийн гүйцэтгэх үүрэг их гэж тус салбарын мэргэжилтнүүд ярьж байна. Энэ нь тогтвортой бизнес харилцаагаар говийн экологийн тэнцвэрт байдлыг хадгалахад туслах мэдээллийн систем юм. Та гайхаж байж магадгүй л дээ. Уул уурхайн компани олборлолтын явцын тайлангаа, бүс нутгийн иргэд нутаг орны нийгмийн байцлын тухай, орон нутгийн захиргаа олборлолт хийхтэй холбоотой хууль эрх зүйн мэдээлээ тус системд нэгтгэж байгаа хэрэг. Уул уурхай ашиглах, байгаль орчноо хамгаалах асуудал хэзээнээсээ л зөрчилдөг ирсэн. Нэг нь газрын гадаргыг хамгаалахад чиглэсэн бол нөгөөх нь түүний дорх эрдэнэстэйг авах сонирхолтой. Аль алиндаа дараа бололгүйгээр үйл ажиллагаагаа явуулах боломж уул нь бий л дээ. Гэсэн ч харууцлагатай уул уурхай гэдэг ойлголт манайд төдийлэн хэрэгждэггүй болохоор дээрх хоёр салбар заавал эсрэгтэж таардаг. Тэгвэл энэ асуудалд шийдэл олох нэгэн гарц байгаа тухай дээрх чигэнд чимэгтэй мэдээг дуулгалаа.

Канадын Олон улсын хөгжлийн судалгааны төвийн дэмжлэгтэйгээр манайд хэрэгжж буй “Dream IT” буюу Мэдээлэл харилцаа, холбооны технологи /МХХТ/-ийг ашиглан монголчуудыг чадваржуулах хөгжлийн судалгааны төслийг онгөрсөн жилээс хэрэгжүүлж эхэлжээ. Уг төсөл боловсрол, засаглал, байгаль орчин-уул уурхай, эрүүл мэндийн салбарт хэрэгжих ёстой бөгөөд тус салбаруудад МХХТ-ийн боломжийг хэрхэн үр дүнтэй ашиглах талаар үндэсний семинарыг өчигдөр зохион байгуулсан юм. Уг семинарын үеэр яригдсан

гол асуудлын нэг нь мэдээж байгаль орчин, уул уурхайн салбар байв. Тэр дундаа говийн бүсийн уул уурхайн тухай асуудал энд нэлээд чухал байр суурьтай яригдсан юм. Монголын говь нь ургамал амьтан, байгалийн баялгаар арван боловч хүний идэвхит үйл ажиллагаа, хотжилт, уул уурхайн салбарын үйл ажиллагааны улмаас олон сөрөг нөлөө учирч байгаа аж. Дэлхийн дулаарал болон говийн бүс дэх уул уурхайн үйл ажиллагаанаас болж наад зах нь усны нөөц нь эрс хомсдсон гэх. Тиймээс уг бүс нутагт ард иргэд, төр засаг, уул уурхайн компанийн хоорондох бизнес харилцааг мэдээллийн систем ашиглан бэхжүүлж, бүсийн байгаль орчныг хамгаалах “Миний нутаг” мэдээллийн сүлжээний төслийг Өмнөговь аймгийн Номгон суманд хэрэгжүүлсэн ЖЭМР ХХК энэ үеэр үйл ажиллагаагаа тайлагнаа. Номгон сум 18.734.2 ам км нутагтай бөгөөд 57.8 хувьд нь уул уурхайн лиценз олгогджээ. Үүнд хайгуулын 29, ашиглалтын зургаан компани багтдаг аж. Хоёр жилийн өмнө “ЖЭМР” ХХК-д Номгон сумын нутагт нүүрсний орд барих суурь судалгаа хийх захиалга иржээ. Ингээд судалгааны ажил хийх явцад нутгийн залуус “дан ганц мал малаад амьдралаа авч явна гэдэг бүтэцтэй хэрэг. Тиймээс бид ч гэсэн уул уурхайн салбарт ажилламаар байна. Бас манай нутагт үйл ажиллагаа явуулдаг уул уурхайн компаниудын мэдээлүүдтэй танилцах хүсэлтэй байдаг” гэдгээ илэрхийлсэн байна. Мөн тэднийг мэргэшүүлэн, ажлын байраар хангах хүсэлт ч ирсэн байна. Хэрвээ уул уурхайн компани, иргэд хоорондын харилцааг сайжруулж, мэдээллийн нэгдсэн сүлжээнд оруулснаар иргэд нөхөн сэргээлт хийхийг тухайн компаниас шаардаж, тус ажил ямар шатандаа яваа мэдээллийг цаг алдалгүй авч байх аж. Мөн нутгийн иргэд ажлын байраар хангагдаж, үл облогогшдууд ч багасах талаар судалгааны



ажилтнууд ярьж байна.

Уул уурхайн салбар хөгжихийн хэрээр нүүдэлчин ахуй, соёлд тодорхой өөрчлөлт гарах нь мэдээж. Тиймээс нутгийн иргэдийг энэхүү өөрчлөлтөд зохицоход нь туслах ажлыг нь мэдээллийн системийн тусламжтайгаар хийх аж. Гурван сарын хугацаанд хэрэгжүүлсэн төслийн ажил дууссан хэдий ч төслийн үр дүнгээс хамаарах дахин гүйцэтгэл хийх, сайжруулах, хамрах хүрээг өргөтгөх талаарх асуудлыг уулзалтын үеэр ярьсан. Тухайлбал, “Иргэний боловсрол” ТББ-ын төлөөлөгч Н.Батжаргал “Төслийн ажлын үр дүнгүүд эхнээсээ харагдаж эхэлж байгаа нь сайшаалтай. Бид бас хангайн аймгуудад дээрхтэй адил төсөл хэрэгжүүлж байсан. Ерөнхийдөө төслийн үндэслэл, зорилгын хувьд ижилхэн юм. Та бүхний санаачлан хийсэн “Миний нутаг” мэдээллийн системийг өөрсдийнхөө ажилд ашиглавал үр дүнд хүрэхээр байна” гэв.

Энэ удаагийн уулзалтад БОАЖИ, ЭБЭХИ, МХЕГ болон тус бүс нутагт олборлолт хийдэг уул уурхайн компаниуд, нутгийн иргэдийн төлөөлөл оролцсон нь арга хэмжээний ач холбогдлыг улам нэмэгдүүлсэн.

Номгон сумын ИТХ-ийн дарга З.Амарсанаа:

“Өндөр хүрдтэй мэдээллийн систем байтугай гар утсаа ч ажиллуулж чаддаггүй хөдөөгийн

иргэд интернэт, компьютер ашиглаж мэдээлэл авах нь хүнд рэлтэй асуудал шүү дээ. Гэхдээ хэцүү гээд бид шантраггүй хөдөөгийн олон иргэд компьютер ашиглан мэдээлэл авч сурч байгаа. Иргэдэд уул уурхайн салбарын мэдээлэл дутмаг байдаг асуудал хийж буй компани иргэдийн хооронд ихээхэн зөрчил гардаг байсан. Нэгдсэн мэдээллийн системтэй болсноор байдал арай дээрдсэн ч манай суманд уул уурхайн үйл ажиллагаа явуулж байгаа компаниуд төдийлэн идэвх санаачлагатай оролцохгүй байна.

Тус сумын малчин иргэн Б.Данамаа:

“Би нутгийн малчиддаа тус төсөл хөтөлбөрийн талаарх мэдээллийг түгээх ажлыг хийж байгаа. Өнгөрсөн оноос эхлэн манай нутагт шороон шуурга таних нь ихэссэн. Энэ мэдээж уул уурхайн компаниудын үйл ажиллагаатай холбоотой. Гэхдээ та нараас боллоо гээд уурлаад дайрах биш, асуудлыг эв найрамдалтайгаар шийдэхэд энэхүү мэдээллийн системийн үүрэг их байгаа гэв.

Энэ үеэр нээлттэй мэдээллийн системийн жингээ болгож “South Gobi sands” компани байгаль хамгааллын үйл ажиллагааныхаа талаарх мэдээллийг танишуулсан юм. Канадын хөрөнгө оруулалттай

компани Өмнөговь аймгийн Гурвантэс суманд олборлолт хийдэг бөгөөд Номгоны “Цагаан толгой” гэдэг газар хайгуулын ажил хийхээр судалгаа явуулж байгаа аж. Тиймээс өнгөрсөн жил тус сумын иргэдийг Гурвантэс суманд хайгуулах үйл ажиллагаатай танишуулж, мэдээлэл өгсөн байна. Тэд өнгөрсөн хугацаанд Гурвантэс сумын ширгэх аюулд өртсөн зургаан булгийг өөрсдийн хөрөнгөөр тохижуулж, нутгийн иргэдэд хүлээлгэн өгсөн байна. Уурхайнхаа шүүрлийн усыг цэвэршүүлж дахин ашиглах зорилгоор тунгаах цөөрөм байгуулснаа ч энэ үеэр танишуулсан. Мөн сумын дунд сургуультай хамтран нутгийн уугуул ургамлын үрийг хүүхдүүдээр түлгэж, кг тунмыг нь өндөр үнээр худалдан авсан байна. Илгит 500 орчим кг үр түүж, үүнийгээ нутгийн хөрсөнд суулгаж төгөл байгуулжээ. Өмнө нь тус компани жиндээ нэг удаа нутгийн иргэдтэй уулзалт зохион байгуулдаг байсан бол мэдээллийн нэгдсэн системтэй болсноор хэзээ л бол хэзээ цахим хуудас ашиглан мэдээлэл солилцох боломжтой болсон байна.

Тус төслийн удирдагч доктор Р.Оюунтай уулзаж зарил зүйлийг тодрууллаа.

“Уулуурхайн компаниудын оролцоо муу байсан талаар түүрэн ярьсан. Тэдэнд мэдээлэл очоогүй юм уу, тэд тооцоогүй юм уу? -Анхны юм алдаатай оноотой л байдаг шүү дээ. Төсөл хэрэгжүүлсэн гурван сарын хугацаагаар төслийг тэр чигт нь үнэлж болохгүй. Гэхдээ бүх уул уурхайн компани оролцоогүй гэвэл өрөөстөл болно. Энэ удаагийн уулзалтад тус нутагт уул уурхайн үйл ажиллагаа явуулдаг цөөнгүй компанийн төлөөлөл ирсэн. Тэд төслийн үр дүнтэй танилцаад цаашид хамтран ажиллана гэдэгт итгэлтэй байна. Харин нутгийн иргэд малчид нэлээд ач холбогдол өгч, идэвх санаачлагатай оролцсон.

Жингээлэл, малчин Дорж мэдээллийн сүлжээнд нутаг орныхоо тухай мэдээлэл оруулахын тулд дурын цахим сүлжээ ашиглан орох уу, тусгай сөрвэр ашиглах уу. Хөдөөгийн ихэнх иргэд G-Mobile -ийн гар утастай байдаг шүү дээ. Түүгээрээ дамжуулан мэдээлэл солилцох боломжтой юу?

“Интернэтийн ямар сүлжээ ашиглаж байгаагаас үл хамааран, хэн ч хаанаас ч мэдээллийн төнд холбогдож мэдээлэл солилцох боломжтой. Хөдөөгийн иргэд мэдээллийн шинэ технологийг ашиглах талаарх мэдлэг дутмаг байгаа учир тусгай сөрвэр ашиглах боломжгүй юм л даа гэв.